



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/74

Булган сум

“Шүд угаалтын аварга” шалгаруулах тэмцээн зохион байгуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын зорилт 2.2 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.“Эрүүл шүд” арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн “Шүд угаалтын аварга” шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсугай.

2. Тэмцээний удирдамжийг 1 дүгээр, зарцуулагдах хөрөнгийн төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээний бэлтгэл, бэлэн байдлыг ханган, чанартай, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Эруул мэндийн газар (П.Оюунцэцэг)-т даалгасугай.

4. Тэмцээнд зарцуулагдах 3,204,000 (гурван сая хоёр зуун дөрвөн мянга) төгрөгийг төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.



Аймгийн Засаг даргын 2025. оны
02. дугаар сарын 09.-ны/ний өдрийн ... дүгээр
захирамжийн 1 дүгээр хавсралт

**БУЛГАН АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН
4-7 ДУГААР АНГИЙН СУРАГЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
“ШҮД УГААЛТЫН АВАРГА” ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

Үндэслэл: Дэлхий эрүүл мэндийн байгууллагаас 2000 онд шүд цоорох өвчнийг олон шалтгаант халдварт өвчин хэмээн халдварт өвчний ангилалд оруулсан. “Эрүүл шүд” арга хэмжээний хүрээнд Булган аймгийн хэмжээнд 2024 онд 9612 хүүхдийн дунд хийгдсэн судалгаанаас үзэхэд сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийн дунд шүд цоорох өвчний тархалт 83 хувьтай байна.

Энэхүү арга хэмжээний хүрээнд 2024 оны 03 дугаар сараас эхлэн Ерөнхий боловсролын сургуулиудын бага ангиудад “Шүд угаах цаг” аяныг зохион байгуулан 11 сарын байдлаар 4901 сурагч өдөр бүр шүдээ угааж сурсан.

Зорилго: Булган аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын хүүхдүүдийн амны хөндийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, шүд угаах зөв аргачлалыг эзэмшигүүлэх, шүд угаахын ач холбогдлыг олон нийтэд таниулах, сурталчлах, үүний үр дүнд хүүхдүүдийн амны хөндийн өвчлөл буурна.

Хамрах хүрээ: Ерөнхий боловсролын сургуулийн эмч, эрүүл мэндийн хичээлийн багш, 4-7 дугаар ангийн сурагчид, сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн шүдний эмч, эмчлэгч эмч, арга зүйч нар

Бэлтгэл ажлын хүрээнд:

- 1.Боловсролын газарт мэдээллийг танилцуулах
2. Боловсролын газартай хамтран Ерөнхий боловсролын сургуулиудын эрүүл мэндийн багш нарыг цахим сургалтад хамруулах
- 3.Сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн шүдний эмч (шүдний эмчгүй сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн их эмч), арга зүйч нарыг сургалтад хамруулах
- 4.Гарын авлагаар хангах

НЭГ. ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 1.Тэмцээн 6 минутын сүлд дуутай, тэмцээний лого тэмдэгтэй байна.
- 2.Тэмцээнийг 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулагдана.
3. Аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 4-7 дугаар ангийн /9-13 насны/ сурагчдыг тэмцээнд хамруулна.
- 4.Тухайн насны сурагчдын тооноос хамааран сургууль бүрээс тус бүр 8-н хүүхдийн бүрэлдэхүүнтэй 1-2 баг тэмцээнд оролцено.
- 5.Багийн гишүүд бүгд эрүүл шүдтэй байх шаардлагыг хангасан байна. /Шүдээ авхуулсан, ломбодуулсан, өвчтэй шүдтэй бол хасагдах шалгуур болно/
- 6.Багууд жигд, ижил хувцаслана.

7. Багууд бүгд тэмцээн эхлэхээс өмнө багийн уриагаа хэлж танилцуулна. /багын уриа нь багийн нэр болон шүдний эрүүл мэндтэй холбоотой 2-4 өгүүлбэрт багтсан байна./

8. Тэмцээнийг 5 өртөөгөөр, өртөөчилсөн хэлбэрээр зохион байгуулна..

- a. a.1-р өртөө: Хүлээх хэсэг
- b. b.2-р өртөө: Шүд угаалтын онолын шалгалт, жигнэмэг идүүлнэ
- c. c.3-р өртөө: Шүд угаалт, шүдний утас хэрэглэх, шүд угаалтыг хянах, оноо өгөх,
- d. d.4-р өртөө: Шүдний гадаргуу дээрх өнгөрийг будна.
- e. e.5-р өртөө: Шүдний гадаргуу дээрх өнгөрийг үнэлнэ.

9. Шүд угаалтын тэмцээнийг доорх зураглааар зохион байгуулна.

Тайлбар:

 Ширээ

 Ширээ

 Ширээ


 Сандал

 Сандал

 Үзлэгийн ор

 Хогийн сав
/энгийн/

 Хогийн сав
/эмнэлгийн/



№ 1. Тэмцээний талбайн зохион байгуулалтын схем зураглал:

Өртөө бүр 8-н хэсэгтэй байна.

1.1-р өртөөнд багш нар сурагчдыг зохион байгуулна. 2,4-р өртөөн дээр тус бүр 8 шүүгч, 3,5-р өртөөн дээр тус бүр 16 шүүгч ажиллана.

2.2-р өртөөний шүүгч нь Булган аймгийн багш нар, бусад өртөөн дээр Булган аймгийн шүдний эмч, сувилагч, техникч, мэргэжилтнүүд байна.

3.Өртөө тус бүр дээр 6 минут зарцуулна.

4.1-р өртөө: Хүлээх хэсэг. Багш багуудыг хувцсаар жигдруулж, багийг бэлтгэнэ.

2-р өртөө: Сурагчид шүд угаалтын талаарх 10 асуулт бүхий онолын тест бөглөж, шүдийг санаатайгаар бохирдуулах зорилгоор жигнэмэг иднэ.

3-р өртөө: Шүдээ Бассын аргаар оогүйгээр угааж, шүдний завсрыйг шүдний утсаар цэвэрлэн шүд угаалтыг үнэлүүлнэ

4-р өртөө: Шүдний гадаргуун дээрх өнгөрийг тодорхойлохдоо будагч бодис бүхий шахмалыг шүдний бүх хэсгээр сайтар зажлуулна. Зажлах явцдаа шахмалыг залгихыг хатуу хориглоно.

5-р өртөө: Шүдний гадаргуу дээрх өнгөрийг эмч нэг удаагийн багаж хэрэгсэл ашиглан үзлэг хийн, тусгай үнэлгээний хуудсаар үнэлж оноог нэгтгэнэ.

5.Нэг өртөөн дээр 6 минут, нийт 24 минут зарцуулах ба тус хугацаанд тэмцээний сүлд дуу 4 удаа явна.

ХОЁР: ТЭМЦЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хаана: Булган сумын Соёлын ордны зааланд

Хэзээ: 2025 оны 1 сарын 31-ны өдөр 900 -1500 цагт

Зохион байгуулагч:

- Эрүүл мэндийн яам /ЭМЯ/
- Булган аймгийн Засаг даргын Тамгын газар
- Булган аймгийн Эрүүл мэндийн газар
- Булган аймгийн Боловсролын газар
- Анааахын шинжлэх ухааны Үндэсний Их сургуулийн Нүүр ам судлалын сургууль /НАСС/

ГУРАВ: ТЭМЦЭЭНИЙ ДҮН ГАРГАХ, ШАГНАЖ УРАМШУУЛАХ

1.Тэмцээнд оролцсон 20 багаас 2-5-р өртөөний нийлбэр оноогоор тэргүүлсэн 3 багийг шалгаруулж байр эзлүүлнэ.

1-р байр-400.000₮, өргөмжлөл

2-р байр -300.000₮ , өргөмжлөл

3-р байр- 200.000₮ , өргөмжлөл

2.Хамгийн сайн шүд угаасан, онолын шалгалтан дээр өндөр оноо авч, нийлбэр оноогоор тэргүүлсэн 3 сурагчийг шалгаруулсан шагнана. Сурагч тус бүр 100.000₮*3= 300.000₮

Аймгийн Засаг даргын 20..... оны
..... дугаар сарын-ны/ний өдрийн дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

“Шүд угаалтын аварга” шалгаруулах тэмцээний
болон бэлтгэл ажлын санхүүгийн тооцоо

Д/Д	Ашиглагдах материал	Тоо ширхэг	Нэгж үнэ	Өртөг
1	2	3	4	5
1.	Сойз	240	5,000	1,200,000
2.	Шүдний утас	240	5,000	1,200,000
3.	Ус	300	1,000	300,000
4.	Өнгөр тодорхойлогч шахмал	240	600	144,000
5.	Үзлэгийн нэг удаагийн толь	240	1,500	360,000
	НИЙТ			3,204,000